УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН ТУШААЛ

2020 оны 06 сарын 11 өдөр Дугаар А/195 Улаанбаатар хот

"Шарилжгүй Улаанбаатар-5"
аян зохион байгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйл, 21 дүгээр зүйлийн 21.3, Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.2, 2.7 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ургамлын харшлаас урьдчилан сэргийлэх зорилгоор "Харшлын эсрэг хамтдаа" уриан дор "Шарилжгүй Улаанбаатар-5" аяны 1-р үе шатыг 2020 оны 06 дугаар сарын 20-ноос 07 дугаар сарын 05-ны өдрүүдэд, 2-р үе шатыг 2020 оны 08 дугаар сарын 05-аас 08 дугаар сарын 20-ны өдрүүдэд тус тус зохион байгуулах ажлын удирдамжийг 1 дүгээр, аяныг зохион байгуулахад шаардагдах зардлын тооцоог 2 дугаар хавсралт ёсоор тус тус батлсугай.

2. Аяныг нийтийн эзэмшлийн гудамж талбай, байгууллага аж ахуйн нэгж, гэр хорооллын айл өрх болон эзэнгүй барилгын хашаа, орон сууцны байр орчим, хүүхдийн тоглоомын талбай, гэр хорооллын гудамж, гуу жалга зэрэг байршлуудад ургасан хөл газрын ургамалыг тайрч, хадан малын тэжээл бэлтгэхэд ашиглах, хотын гол гудамж зам дагуу жил бүр их хэмжээгээр шарилж лууль ургадаг байршлуудад хөл газрын ургамлын ургалтыг зогсоож дахин ургуулахгүй байх үйлчилгээтэй БНСУ-д үйлдвэрлэгдсэн хүний биед хор нөлөөгүй зориулалтын эко бэлдмэлийг хэрэглэх чиглэлээр зохион байгуулж, аяны үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар ханган, хяналт тавьж, сурталчилж ажиллахыг Хог хаягдлын удирдлага, зохицуулалтын хэлтэс /С.Аригуун/-т даалгасугай.

3. Батлагдсан удирдамж, энэхүү тушаалаар өгөгдсөн чиглэлийн дагуу аяны үйл ажиллагааг дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг идэвхитэй оролцуулж ажиллахыг дүүргүүдийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Аяныг зохион байгуулахад шаардагдах **199,533,762** /Нэг зуун ерөн есөн сая таван зуун гучин гурван мянга долоон зуун жаран хоёр/ төгрөгийг Гэр хороолол, орон сууцны хороолол доторх зэрлэг ургамлыг устгах зардлаас санхүүжүүлэхийг Ахлах нягтлан бодогч /Б.Цэрмаа/-д зөвшөөрсүгэй.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА Т.ГАНТӨМӨР

c:\users\gantuya\desktop\үж 12\doc 2020\тушаал 2doc.docx

1110300663

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2020 оны 06 дугаар сарын 11 өдрийн
А/195 тушаалын 1 дүгээр хавсралт

“ХАРШЛЫН ЭСРЭГ ХАМТДАА” УРИАТАЙ “ШАРИЛЖГҮЙ УЛААНБААТАР-5” АЯНЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ

1. Зорилго:
Хөл газрын ургамалын тоосноос үүдэх харшлын өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, өвчлөлийн тоог бууруулах, хөл газрын ургамлыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тайрах, хадах, ногоон масс болон малын тэжээл болгон ашиглах, иргэдэд нэгдсэн мэдлэг, зөв ойлголтыг өгөх, цэвэрлэгээний үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, хөл газрын ургамалын ургалтыг зогсоож дахин ургуулахгүй байх үйлчилгээтэй дэвшилтэт технологи бүхий эко бэлдмэлийг хэрэглэхэд энэхүү аяны зорилго оршино.

2. Хамрах хүрээ: Нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд зохион байгуулагдана.

3. Хугацаа:
- 1-р үе шат 2020 оны 06 дугаар сарын 20-оос 07 дугаар сарын 05-ны өдрүүдэд,
- 2-р үе шат 2020 оны 08 дугаар сарын 05-аас 08 дугаар сарын 20-ны өдрүүдэд зохион байгуулагдана.

4. Оролцогч талууд: Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар, хог хаягдал, ногоон байгууламжийн ажил үйлчилгээнд хөндлөнгийн хяналт хэрэгжүүлдэг төрийн бус байгууллага, хог хаягдлын үйлчилгээний байгууллагууд, нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага, аж ахуйн нэгж, иргэд.

5. Аяны үйл ажиллагааны чиглэл:
5.1 Хотын гол гудамж зам дагуу жил бүр тогтмол их хэмжээгээр ургадаг байршлуудад хөл газрын ургамалын ургалтыг зогсоож дахин ургуулахгүй байх үйлчилгээтэй БНСУ-д үйлдвэрлэгдсэн хүний биед хор нөлөөгүй зориулалтын эко бэлдмэлийг хэрэглэх
5.2 Нийтийн эдэлбэр газар ихээр ургасан хөл газрын ургамлыг иргэдийн бүлгийн оролцоотойгоор тайралт таналт хийлгэх,
5.3 Байгууллага, аж ахуйн нэгж, гэр хорооллын айл өрх, эзэнгүй барилгын хашаан доторх болон хашааны гаднах хашаа дагасан хөл газрын ургамлыг цэвэрлүүлэх
5.4 Тайрж, хадсан хөл газрын ургамалыг малын тэжээл болгон хот орчмын малтай иргэдэд өгөх,
5.5 Хөл газрын ургамалын тайралт, таналтын технологийн талаар иргэдэд мэдээлэл өгөх.

6. Аяны ерөнхий зохион байгуулалт:
6.1 Аяны хугацаанд Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн баталсан 2020 оны “Их цэвэрлэгээний хуваарь батлах тухай” 01 дүгээр тушаалын дагуу хөл газрын ургамалыг цэвэрлэх, тайрч, танах бүх нийтийн нэгдсэн арга хэмжээг 2020 оны 07 дугаар сарын 04, 08 дугаар сарын 15-ны Бямба гаригуудад тус тус зохион байгуулна.

6.2 Бүх нийтийн арга хэмжээний өдөр Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас зааж өгсөн байршлуудад иргэдийн бүлгийг дүүрэг харгалзахгүйгээр нэгдсэн зохион байгуулалттайгаар ажиллуулах ба хог хаягдлын үйлчилгээний байгууллагууд иргэдийн бүлгийг зориулалтын багаж хэрэгслэлээр бүрэн хангаж ажиллана.

6.3 Бүх нийтийн арга хэмжээний өдөр дүүрэг бүр хуваарь гаргаж, нэгдсэн зохион байгуулалттайгаар дүүргийн нутаг дэвсгэрт хөл газрын ургамалын цэвэрлэгээг иргэд, аж ахуйн нэгжийн оролцоотойгоор зохион байгуулна.

6.3 Аяны 1, 2 дугаар үе шатны хугацаанд бусад өдрүүдэд хороо тус бүрээр баталсан аяны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу өдөр бүр тасралтгүй хөл газрын ургамалын тайрлт, таналтын үйл ажиллагааг зохион байгуулна.

№	Байгууллагын нэр	Хариуцах ажил үүрэг
1	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба	1. Аяныг нэгдсэн удирдлага, чиглэлээр хангах 2. Оролцогч талуудын үйл ажиллагааг уялдуулах 3. Аяныг сурталчилсан нэгдсэн видео болон зурагт хуудас, сурталчилгааг бэлтгэж, сошиал медиа, ТВ, радиогоор сурталчлах, хэвлэлийн бага хурал зарлаж, иргэдэд аяны талаар мэдээлэл өгөх 4. Бүх нийтийн арга хэмжээний өдөр иргэдийн бүлгийн цэвэрлэгээг зохион байгуулах, 5. БНСУ-д үйлдвэрлэсэн хөл газрын ургамалын ургалтыг зогсоох үйлчилгээтэй эко бэлдмэлийг төлөвлөсөн талбайд хэрэглэх ажлыг зохион байгуулах
2	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар	1. 2020 оны 07 сарын 04, 08 дугаар сарын 15-ны Бямба гаригт зохион байгуулагдах бүх нийтийн арга хэмжээний өдөр аж ахуйн нэгж байгууллагын орчны 50м хүртэлх талбай, эзэнгүй барилгын хашааны шарилж, луулийг цэвэрлэх үйл ажиллагаанд хяналт тавих, цэвэрлэгээний ажилд хангалтгүй оролцсон ААНБ-уудад хариуцлага тооцох
3	Дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар	1. 2020 оны 07 сарын 04, 08 сарын 15-ны Бямба гаригт зохион байгуулагдах бүх нийтийн арга хэмжээг дүүргийн хэмжээнд зохион байгуулах, төлөвлөгөө гаргаж ажиллах 2. Аяны хугацаанд хороо бүрээр ажлын төлөвлөгөө, цэвэрлэгээ хийх талбайн хуваарь гаргуулах ажлыг зохион байгуулах, хороодыг нэгдсэн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллах 3. ААНБ, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор бүх нийтийн арга хэмжээний өдөр хөдөлгөөнт чанга яригчаар уриалга, сурталчилгаа явуулах, ажлыг зохион байгуулах 4. Удирдамжид заасан чиглэлийн дагуу нутаг дэвсгэрийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг хөл газрын ургамлыг хадах, тайрах ажилд идэвхитэй оролцуулах

		5. Олон нийтийн байцаагчдыг ажиллуулж, зөрчилтэй болон цэвэрлэгээний ажилд оролцоогүй, орчиндоо хөл газрын ургамалтай аж ахуйн нэгж байгууллагуудад зөрчлийн тэмдэглэл үйлдэж, мэргэжлийн хяналтын улсын байцаагчидтай хамтран арга хэмжээ авч ажиллах 6. Цэвэрлэгээнээс гарсан хөл газрын ургамлыг бөөгнүүлж, буулгах байршлыг тодорхойлж, тогтоосон байршил уруу тээвэрлүүлэх, хадаж, тайрсан хөл газрын ургамлыг малын тэжээл болгох зорилгоор мал бүхий иргэдэд түгээх ажлыг тус тус зохион байгуулах
4	Хороо	1. Аяны хугацаанд өдөр бүр ажиллах төлөвлөгөө хуваарь гарган, нутаг дэвсгэрийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг идэвхтэй оролцуулах, аяны зорилго, үйл ажиллагааг сурталчлах, мэдээлэл өгч ажиллах
5	Хог хаягдлын ажил үйлчилгээнд хөндлөнгийн хяналт хэрэгжүүлдэг ТББ	1. Аяны нийт 30 хоногийн хугацаанд иргэдийн бүлгийг багийн зохион байгуулалтад оруулан хуваарийн дагуу зөвхөн хөл газрын ургамал цэвэрлүүлэх ажлыг шууд удирдлагаар зохион байгуулж, хяналт тавьж ажиллах. 2. Багийн зохион байгуулалтаар ажиллах иргэдийн бүлгийн цэвэрлэгээний өдөр тутмын хуваарийг хог хаягдлын үйлчилгээний багууллага, хороодтой хамтран гаргах 3. Аяны хугацаанд орчныхоо хөл газрын ургамлыг цэвэрлээгүй аж ахуйн нэгж, байгууллагуудын талаарх мэдээллийг тухайн дүүргийн Мэргэжлийн хяналтын улсын байцаагчид өгч арга хэмжээ авахуулах
6	Зам цэвэрлэгээний байгууллага, аж ахуйн нэгжүүд	1. Төлөвлөгөөнд заасан өдөр нэгдсэн зохион байгуулалттайгаар батлагдсан хуваарийн дагуу хөл газрын ургамлыг цэвэрлэх 2. Хариуцсан гудамж, зам талбайн хашаа, барилга дагасан хэсэг, явган хүний замаас барилга, хашаа хүртэлх хэсгийн хөл газрын ургамлыг цэвэрлэх 3. Цэвэрлэсэн хөл газрын ургамлыг нэг дор цуглуулж тээвэрлэхэд бэлэн болгож тогтоосон цэгт тээвэрлүүлнэ.
7	Ногоон байгууламжийн арчилгааны аж ахуйн нэгжүүд	1. Төлөвлөгөөнд заасан өдөр нэгдсэн зохион байгуулалттайгаар хуваарьт гудамжны хөл газрын ургамлыг цэвэрлэх
8	Дүүргүүдийн хог хаягдлын үйлчилгээний байгууллага	1. Дүүрэг, хорооноос баталсан хуваарийн дагуу хариуцсан хорооны нутаг дэвсгэр дэх жалга, эзэнгүй талбайд ургасан хөл газрын ургамлыг цэвэрлэх 2. Хяналтын ТББ-уудтай хамтран иргэдийн

		бүлгийг багийн зохион байгуулалтаар ажиллуулах, 30 хоногийн турш цэвэрлэгээ хий талбайн хуваарийг гаргаж, хуваарийн дагуу ажиллуулах 3. Хөл газрын ургамал цэвэрлэх хүмүүсийг шаардлагатай багаж хэрэгслэлээр хангах. 4. 2020 оны 07 сарын 04, 08 дугаар сарын 15-ны Бямба гаригт зохион байгуулагдах бүх нийтийн арга хэмжээний өдрийг угтаж болон тухайн өдөр чанга яригчаар иргэн ААНБ-ыг цэвэрлэгээний ажилд оролцохыг уриалж, сурталчлах 5. Дүүргийн ЗДТГ-аас тогтоосон байршилд тайрч, хадсан хөл газрын ургамлыг тээвэрлэх

8. Хөл газрын ургамлыг тайрах, хадах аргачлал: Хөл газрын ургамлыг цэцгийн тоосоо гөвөхөөс урдчилан сэргийлж доод ишнээс 10-15 см өндөртэйгөөр зориулалтын хайч, гар болон автомат хадуураар тайрна. Хөл газрын ургамлыг 10-15 см өндөртэй үлдээж хэд хэдэн давтамжтай тайрснаар луйлны бутлалт салаалт явагдсанаар навчны эзлэх хэмжээ нэмэгдэн, агаарын тоосжилтын хэмжээг бууруулахад зохистой нөлөө үзүүлдэг. Мөн хөл газрын ургамал хүчирхэг үндэстэй тул үндэс нь хөрсөнд үлдсэнээр хөрсийг сийрэгжүүлж, хөрсний элэгдэл үүсэх, сул шороон талбай үүсэхээс хамгаалдаг ба зулгаахгүйгээр тогтмол тайралт хийснээр хөрсний бүтцийг сийрэгжүүлж, үржил шимийг сайжруулан зүлэг болон бусад ургамалууд ургаж эхэлдэг. Тайрсан хөл газрын ургамлыг хог хаягдал, шороо, чулуутай холихгүйгээр цуглуулж авах ба тайрсан ургамлыг хатаах эсвэл даршлах аргаар малын тэжээл бэлтгэх боломжтой. /ХААИС-ын Мал аж ахуйн био технологийн сургуулийн эрдэм шинжилгээ эрхэлсэн орлогч захирал бэлчээр тэжээлийн мэргэжилтэн Д.Гүрбазар, Харшлын өвчин судлалын үндэсний төвийн лабораторийн ажилтан харшлын өвчин, ургамал судлаач Сангидоржийн зөвлөмжөөс/

9. Аяныг тайлагнах:

9.1 Хог хаягдлын үйлчилгээний байгууллага, хороод ажлын тайлангаа харьяалах дүүрэгтээ тухай бүр өгч нэгтгүүлнэ.

9.2 Дүүргүүд 2020 оны 07 сарын 04, 08 сарын 15-ны Бямба гаригт зохион байгуулсан бүх нийтийн арга хэмжээний тайланг дараа өдрийн 12:00 цагаас өмнө Улаанбаатар хотын Шуурхай удирдлага зохицуулалтын төвийн dispatcher_ub@yahoo.com цахим хаягаар хүргүүлэх,

9.3 Улаанбаатар хотын Шуурхай удирдлага зохицуулалтын төв дүүргүүдээс ирсэн мэдээг нэгтгэж, 2020 оны 06 сарын 28, 08 сарын 16-ны өдрийн 17:00 цагаас өмнө Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хог хаягдлын удирдлага, зохицуулалтын хэлтэст хүргүүлнэ.

9.4 Аяны эцсийн нэгдсэн тайланг дүүрэг бүр албан бичгээр Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд 2020 оны 08 дугаар сарын 22-ны дотор хүргүүлнэ.

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2020 оны 06 дугаар сарын 11 өдрийн
А/195 тушаалын 2 дугаар хавсралт

“ШАРИЛЖГҮЙ УЛААНБААТАР-5” АЯНЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын нэр	Нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ /₮/	Нийт зардал /₮/
1	Хөл газрын ургамалын ургалтыг зогсоож дахин ургуулахгүй байх үйлчилгээтэй, хүний биед хор нөлөөгүй зориулалтын эко бэлдмэл худалдан авах	тонн	2	4,761,905	9,523,810
2	Хөл газрын ургамалын ургалтыг зогсоож дахин ургуулахгүй байх үйлчилгээтэй, хүний биед хор нөлөөгүй зориулалтын эко бэлдмэлийг цацах	мкв	60000	120	7,200,000
3	"Шарилжгүй Улаанбаатар-5" аяны мэргэжлийн багийн ажилчдын 30 хоногийн хугацаанд өдөр бүр тогтмол ажиллуулах зардал /1 хүн: 3971₮ х 9 цаг х 30 өдөр=1.072.132₮/	хүн	136	1,072,132	145,809,952
4	"Шарилжгүй Улаанбаатар-5" аяны мэргэжлийн багийн ажилчдын хувцас	ш	50	90,000	4,500,000
5	"Шарилжгүй Улаанбаатар-5" аяны мэргэжлийн багийн ажилчдын малгай	ш	50	6,000	300,000
6	Иргэдийн бүлгийн ажилчдад маск худалдан авах /1 хүн өдөрт 1 маск зүүхээр тооцов/	ш	4200	500	2,100,000
7	Цэвэрлэсэн хөл газрын ургамлыг СХД-ийн 21-р хороо бордооны үйлдвэрт тээвэрлэж буулгах	рейс	150	180000	27,000,000
8	Гар хадуур	ш	50	10,000	500,000
9	Тармуур	ш	50	10,000	500,000
10	Сурталчилгааны постер хэвлүүлэх /А3/	ш	6000	350	2,100,000
Нийт					**199,533,762**